



УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН  
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2021 оны 05 сарын 26 өдөр

Дугаар 19

Улаанбаатар хот

ХИХ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

Улсын онцгой комиссын хуралдааныг 2021 оны 5 дугаар сарын 26-ны өдрийн 14:00 цагт Төрийн ордон дахь “Нутгийн удирдлагын танхим”-д 72.5 хувийн ирцтэй цахимаар хуралдуулав.

Хурлыг Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга С.Амарсайхан даргалж, холбогдох шийдвэрийг гаргаж, хугацаатай үүрэг даалгавар өгөв.

ХЭЛЭЛЦСЭН АСУУДАЛ:

1. Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах эсэх тухай санал

Эрүүл мэндийн сайд,  
Улсын онцгой комиссын гишүүн С.Энхболд

2. Хилийн боомтын талаар авах арга хэмжээний тухай

Гадаад харилцааны яамны,  
Төрийн нарийн бичгийн дарга Н.Анхбаяр

3. “Гадаад улсаас ирсэн иргэдийг тусгаарлан ажиглах үйл ажиллагааг зохицуулах түр журам”-д нэмэлт өөрчлөлт оруулах төсөл

Эрүүл мэндийн сайд,  
Улсын онцгой комиссын гишүүн С.Энхболд

4. Бусад

## УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН 19 ДҮГЭЭР ХУРАЛДААНЫ ШИЙДВЭР:

*Нэг. Улсын онцгой комиссын гишүүн, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Б.Ганбат, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Улсын онцгой комиссын орлогч дарга, Онцгой байдлын ерөнхий газрын дарга, хошууч генерал Г.Ариунбуян нарт:*

1.1. Засгийн газрын 2021 оны 115 дугаар тогтоолын 1 дэх хэсэгт заасан гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг 2021 оны 6 дугаар сарын 02-ны өдрөөс 2021 оны 6 дугаар сарын 30-ны өдөр хүртэл 28 хоногоор сунгах асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлэх;

1.2. Засгийн газрын 2021 оны 121 дугаар тогтоолын 1 дэх хэсэгт заасан коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, эрсдэлийг бууруулах зорилгоор авто замын болон замын боомтоор улсын хил нэвтрэх зорчигч тээврийн хөдөлгөөнийг 2021 оны 6 дугаар сарын 02-ны өдрөөс 2021 оны 6 дугаар сарын 30-ны өдөр хүртэл 28 хоногоор сунгах асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлэх;

*Хоёр. Улсын онцгой комиссын гишүүн, Эрүүл мэндийн сайд С.Энхболд, ЗГХЭГ-ын Хэвлэл мэдээлэлтэй харилцах газрын дарга Ц.Ганзориг, Улсын онцгой комиссын Шуурхай штабын дарга, хурандаа Ц.Ганзориг нарт:*

2.1. Коронавируст халдвар (Ковид-19)-ын эсрэг вакцинжуулалтын ажлыг улсын хэмжээнд эрчимжүүлж, иргэдийн идэвхийг нэмэгдүүлэх, иргэд олон нийтэд үнэн бодит мэдээ, мэдээлэл хүргэх ажлыг зохион байгуулах;

2.2. Гэрийн тусгаарлалтад байгаа иргэдэд халдвар хамгааллын дэглэм сахих, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах, хэрэглэх эм бэлдмэлийн тухай мэдээ, мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээгээр дамжуулан түгээх;

2.3. Батлагдсан тохиолдлыг тухайн өдөрт нь багтаан хариу арга хэмжээ авахад анхаарч, халдварын тархалтаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажиллах,

2.4. Улсын онцгой комиссын даргын 43 дугаар тушаалаар баталсан “Гадаад улсаас ирсэн иргэдийг тусгаарлан ажиглах үйл ажиллагааг зохицуулах түр журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг нарийвчлан судалж, холбогдох байгууллагууд мэдээлэл солилцон, дахин Улсын онцгой комиссын хуралдаанд танилцуулах;

*Гурав. Улсын онцгой комиссын гишүүн, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Өмнөговь аймгийн Засаг дарга Р.Сэддорж нарт:*

3.1. 2021 оны 5 дугаар сарын 22-ны өдрөөс уул уурхайн компаниудын ажилчдын ээлж солих үйл ажиллагаа эхэлсэнтэй холбогдуулан халдвар хамгааллын дэглэмийг хатуу мөрдүүлж, хяналт тавьж ажиллах;

*Дөрөв. Улсын онцгой комиссын гишүүн, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Т.Гантулга, Хил хамгаалах ерөнхий газрын дарга, бригадын*

4.1. Хилийн Цагааннуур, Боршоо боомтуудад олон улсын стандартад нийцсэн халдваргүйжүүлэлтийн цэгийг байгуулах асуудлыг судалж, Улсын онцгой комиссын хуралдаанд танилцуулах;

4.2. Хилийн Замын-Үүд боомтын халдваргүйжүүлэлтийн цэгийн үйл ажиллагааг сайжруулах, олон улсын стандартад нийцүүлэх арга хэмжээ авах;

4.3. Хилийн хяналт шалгалтыг эрчимжүүлэх,

*Тав. Улсын онцгой комиссын гишүүн, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Т.Гантулга, Гаалийн ерөнхий газрын дарга Б.Асралт нарт:*

5.1. БНХАУ-аас импортоор оруулж ирдэг түргэн муудах, гэмтэх бараа бүтээгдэхүүнээс бусад ачаа барааг төмөр замаар тээвэрлэх, БНХАУ-ын Эрээн өртөөнд автомашинаас төмөр зам руу шилжүүлэн ачих арга хэмжээ авч авто замын боомтын ачааллыг бууруулах асуудлыг судалж шийдвэрлэх, ачаа тээврийн эргэлтийг нэмэгдүүлэх талаар БНХАУ-ын талтай хэлэлцэн шийдвэрлэх;

*Зургаа. Улсын онцгой комиссын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Сангийн сайд Б.Жавхлан нарт:*

6.1. Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн үйлчлэх хугацааг сунгах, нэмэлт өөрчлөлт оруулах асуудлаар хамтарсан ажлын хэсэг байгуулан холбогдох тооцоо судалгааг хийж Улсын онцгой комисс, Засгийн газрын хуралдаанд танилцуулах.

Шийдвэрийн биелэлтийг тооцож, танилцуулж ажиллахыг Улсын онцгой комиссын Нарийн бичгийн дарга, дэд хурандаа Т.Баярхүү, Шуурхай штабын дарга, хурандаа Ц.Ганзориг нарт даалгах.

ДАРГА

С.АМАРСАЙХАН

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА,  
ДЭД ХУРАНДАА

Т.БАЯРХҮҮ